

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2025 оны I улирлын санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	4
Товчилсон нэрсийн жагсаалт	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	7
Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	8
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт	8
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт	8
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	8
Статистик үзүүлэлтүүд	9
Харилцагчид, зээлдэгчид	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид	9
Тархалт	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	12
Хөрөнгө оруулалт	13
Зээл.....	13
Цахим зээл	16
Ногоон зээл	17
Факторингийн тооцооны авлага.....	18
Үүсмэл санхүүгийн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө.....	19
Санхүүгийн бус хөрөнгө.....	19
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	20
Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	21
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр.....	22
Бусад эх үүсвэр	22
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	23
Төслийн зээлийн санхүүжилт	23
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ).....	24
Бусад санхүүгийн өр төлбөр.....	24
Санхүүгийн бус өр төлбөр.....	25
Өөрийн хөрөнгө	25
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	25
Өөрийн хөрөнгийн бусад хэсэг	26
Хуримтлагдсан ашиг	27
Ашигт ажиллагаа	28
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	29
Дүгнэлт	31
Актив, пассивын бүтэц.....	31
Ашигт ажиллагаа	32
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	32

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр).....	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	5
Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл.....	9
Хүснэгт 5 Статистик мэдээлэл (5 жилээр)	9
Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл	10
Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр).....	11
Хүснэгт 11 Активын интервал (тэрбум төгрөгөөр).....	12
Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)	12
Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц (сая төгрөгөөр)	13
Хүснэгт 14 Зээлийн бүтэц (тэрбум төгрөгөөр)	13
Хүснэгт 15 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар (сая төгрөгөөр)	15
Хүснэгт 16 Зээлийн ангилал (тэрбум төгрөгөөр)	16
Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)	16
Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд (мянган төгрөгөөр).....	16
Хүснэгт 19 Ногоон зээлийн тайлан (сая төгрөгөөр).....	17
Хүснэгт 20 Факторингийн тооцооны авлагын ангилал (сая төгрөгөөр)	18
Хүснэгт 21 Бусад хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	19
Хүснэгт 22 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	19
Хүснэгт 23 Пассивын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр)	20
Хүснэгт 24 Итгэлцлийн үйлчилгээ (сая төгрөгөөр)	22
Хүснэгт 25 Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг (сая төгрөгөөр)	22
Хүснэгт 26 Бусад эх үүсвэрийн бүтэц (сая төгрөгөөр)	22
Хүснэгт 27 Төслийн зээл санхүүжилт (сая төгрөгөөр)	24
Хүснэгт 28 Бусад өр төлбөр (сая төгрөгөөр).....	24
Хүснэгт 29 Санхүүгийн бус өр төлбөр (сая төгрөгөөр)	25
Хүснэгт 30 Өөрийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)	25
Хүснэгт 31 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	25
Хүснэгт 32 ХНХ-ийн интервал (тэрбум төгрөгөөр).....	26
Хүснэгт 33 Бусад өмч, сангуудын бүтэц (сая төгрөгөөр).....	26
Хүснэгт 34 Орлого, үр дүнгийн тайлан (харьцуулсан, сая төгрөгөөр)	28
Хүснэгт 35 Орлого, үр дүнгийн тайлан (тэр төгрөгөөр).....	28
Хүснэгт 36 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд (үзүүлэлт бүрээр).....	29
Хүснэгт 37 2025 оны I улирлын байдлаарх валют арилжааны мэдээ (сая төгрөгөөр)	30

Зургийн жагсаалт

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл).....	11
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)	11
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	12
Зураг 4 Зээлийн багцын чанар (тэрбум төгрөгөөр)	14
Зураг 5 Зээлийн багцын чанар (хувиар)	14
Зураг 6 Олгосон зээл (хугацааны ангиллаар).....	15
Зураг 7 Ногоон зээлийн багцын чанар (ногоон таксономийн 12 ангиллаар)	18
Зураг 8 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг).....	20
Зураг 9 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	21
Зураг 10 Итгэлцлийн үйлчилгээний өглөг (тэрбум төгрөгөөр)	21
Зураг 11 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)	23
Зураг 12 Төслийн зээлийн санхүүжилт сүүлийн 5 жилийн байдлаар	23
Зураг 13 Хувьцаат капитал сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	26
Зураг 14 Хуримтлагдсан ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр).....	27
Зураг 15 Тайлант үеийн ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр).....	27
Зураг 16 Ашигт ажиллагааны үзүүлэлт (тэрбум төгрөгөөр).....	28
Зураг 17 Салбарын өгөөжийн үзүүлэлт сүүлийн 5 жилээр	30

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт
СТ	Санхүүгийн тайлан
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ЗМС	Зээлийн мэдээллийн сан

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2025 оны I улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 575 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 44 ББСБ буюу 8.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 96 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 28 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2021-I	2022-I	2023-I	2024-I	2025-I
Шинээр олгосон	1	6	6	15	2
Хүчингүй	3	11	5	13	-
Түдгэлзүүлсэн	-	4	1	7	-
Сэргээсэн	5	5	10	9	-
Нийт ББСБ	530	529	514	531	575
Үүнээс: ХОН	76	85	94	95	96
Үүнээс: ГХО	30	28	25	24	28
Салбар	298	393	428	462	539
Төлөөлөгч	8	8	7	11	12

2025 оны I улирлын байдлаар 2 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн хүчингүй болгосон ББСБ байхгүй байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2025 оны I улирлын байдлаар 72 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	2024-I	2025-I	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	5,062.1	7,568.4	49.5%
Банкны салбартай харьцуулахад хувиар	9.2%	10.8%	1.6%
Нийт өөрийн хөрөнгө	2,917.7	3,884.7	33.1%
Банкны салбартай харьцуулахад хувиар	48.7%	53.4%	4.7%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,655.7	1,818.0	9.8%
Банкны салбартай харьцуулахад хувиар	100.0%	105.3%	5.3%
Нийт зээл	4,249.5	6,325.3	48.8%
Банкны салбартай харьцуулахад хувиар	14.4%	16.1%	1.7%
Нийт орлого	378.1	603.4	59.6%
Нийт зарлага	232.3	371.3	59.8%
Цэвэр ашиг	145.9	232.1	59.1%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 49.5 хувиар өсөж, банкны

салбарын 10.8%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 105.3%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.3 пунктээр өссөн дүн юм.

2025 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 49.5 хувиар буюу 2.5 их наяд төгрөгөөр өсөж 7.6 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 82.8 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 38.6 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 59.6 хувиар буюу 225.3 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 59.8 хувиар буюу 139.0 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 59.1 хувиар буюу 86.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2024-I	2025-I	Тоо	Хувь
	Нийт ББСБ-ын тоо	531	575	44	8.3%
1	Зээл	472	511	39	8.3%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	289	311	22	7.6%
2	Факторингийн үйлчилгээ	61	55	(6)	(9.8%)
3	Төлбөрийн баталгаа гаргах	29	28	(1)	(3.4%)
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	6	-	-
5	Цахим төлбөр мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	47	54	7	14.9%
6	Гадаад валютын арилжаа	167	178	11	6.6%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	56	61	5	8.9%
7	Итгэлцлийн үйлчилгээ	80	90	10	12.5%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	37	50	13	35.1%
9	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	-	-

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 575 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 88.9% нь буюу 511 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 54.1% нь буюу 311 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 178 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 31.0 хувийг, гадаад валютын арилжааны

үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 61 ББСБ нийт ББСБ-уудын 10.6 хувийг бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үеэс өөрчлөгдсөн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 39 ББСБ-аар буюу 8.3 хувиар, гадаад валютын арилжаа 11 ББСБ-аар буюу 6.6 хувиар, итгэлцлийн үйлчилгээ 10 ББСБ-аар буюу 12.5 хувиар, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 13 ББСБ-аар буюу 35.1 хувиар, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 7 ББСБ-аар буюу 14.9 хувиар өссөн бол факторингийн үйлчилгээ 6 ББСБ-аар

буюу 9.8 хувиар, төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа 1 ББСБ-аар буюу 3.4 хувиар тус тус буурсан байна.

2025 оны I улирлын тайлан мэдээний ирц 97.9% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 575 ББСБ-аас 563 ББСБ жилийн тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 10 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 2 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ыг тус тус баталсан. Энэхүү журмаар банк бус санхүүгийн итгэлцлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын хувьд итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 60 хувиас хэтрэхгүй байх, нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн хэмжээ хоёроос дээш хувь бол итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 65-80 хувь хүртэл байх, бусдаас өрийн бичиг гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлсэн ББСБ-ын хувьд гаргасан өрийн бичгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 30 хувиас хэтрэхгүй байх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан ББСБ-ын хувьд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлэх дүн нь өөрийн хөрөнгийн 60 хувиас хэтрэхгүй байх, мөн ББСБ нь дотоодын арилжааны банк, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс зээл болон бусад хэлбэрээр эх үүсвэр татан төвлөрүүлэхгүй байхаар зохицуулсан.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 77 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д, 78 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан. Журмын өөрчлөлтийн хүрээнд ББСБ-аас олгох хэрэглээний зээлд өр, орлогын харьцаа 60 хувиас хэтрэхгүй байхаар, суудлын автомашин барьцаалсан зээл, зээл үнэлгээний харьцаа 60 хувиас хэтрэхгүй байхаар тус тус өөрчлөлт оруулсан.

3. 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр тусгай зөвшөөрөлтэй нийт 300 ББСБ-уудад Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ буюу нэмэлт, өөрчлөлт орсон журмуудын талаар танилцуулах сургалт зохион байгуулсан.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2025 оны I улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 71.0 хувь буюу 407 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 64.6 хувь буюу 370 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

2025 оны I улирлын байдлаар зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 511 ББСБ-ын 97.1 хувь буюу 496 ББСБ Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн аль нэгтэй гэрээ байгуулсан байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7

дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 84 ББСБ, 5,687 удаагийн тохиолдлоор, 685.6 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 5 ББСБ, 43 удаагийн тохиолдлоор, 3.7 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2025 оны I улирлын байдлаар нийт 573 ББСБ-аас 1,464.29 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 83.3% буюу 462 ББСБ 1,220.06 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2025 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 35,807 хувьцаа эзэмшигчдийн 575 ББСБ, 539 салбар нэгж, 12 төлөөлөгчийн газар, 6,197 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 3.7 сая харилцагч, 2.6 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар буурч давхардсан тоогоор 3,739,313-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 43.3 хувиар өсөж 2,581,334-д хүрсэн байна.

Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл

Статистик мэдээлэл	Дун	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	3,739,313	3,019,691	284,638	3,454,675	38,100	3,680,587	58,726	345,603	216,740
Үүнээс: Эмэгтэй	1,970,988	1,615,730	122,050	1,848,938	21,118	1,941,102	29,886	170,982	111,892
Эрэгтэй	1,760,611	1,402,693	155,994	1,604,617	11,776	1,731,838	28,773	174,238	104,446
Хуулийн этгээд	7,714	1,268	6,594	1,120	5,206	7,647	67	383	402
Итгэмжлэгчдийн тоо	13,979	13,977	1,266	12,713	-	13,945	34	6,654	340
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,497	1,442	108	1,389	-	1,497	0	554	0
Зээлдэгчдийн тоо	2,581,334	2,021,610	153,785	2,427,549	-	2,524,176	57,158	345,603	216,737
Хэвийн	2,278,700	1,815,751	120,658	2,158,042	-	2,231,517	47,183	298,332	197,474
Хугацаа хэтэрсэн	103,842	71,790	4,838	99,004	-	100,700	3,142	16,328	6,100
Чанаргүй:	198,792	134,069	28,289	170,503	-	191,959	6,833	30,943	13,163
-Хэвийн бус	70,316	42,415	13,424	56,892	-	68,037	2,279	11,083	4,026
-Эргэлзээтэй	53,045	36,778	3,403	49,642	-	51,215	1,830	10,145	4,755
-Муу	75,431	54,876	11,462	63,969	-	72,707	2,724	9,715	4,382
Зээлдэгчдийн насжилт	2,579,076	2,020,380	152,434	2,426,642	-	2,521,983	57,093	345,220	216,335
18-25 насны	658,487	462,807	27,638	630,849	-	635,959	22,528	59,043	35,939
26-35 насны	992,106	788,275	43,335	948,771	-	974,170	17,936	149,297	98,361
36-45 насны	612,465	503,801	46,579	565,886	-	601,761	10,704	91,152	54,660
46-55 насны	254,556	215,508	25,911	228,645	-	250,101	4,455	35,285	20,583
55-аас дээш	61,462	49,989	8,971	52,491	-	59,992	1,470	10,443	6,792
Зээлдэгчдийн боловсрол	2,579,076	2,020,380	152,434	2,426,642	-	2,521,983	57,093	345,220	216,335
-Дээд	1,425,692	1,130,745	80,102	1,345,590	-	1,399,435	26,257	207,698	146,730
-Тусгай дунд	215,532	173,981	8,325	207,207	-	210,150	5,382	41,944	31,441
-Бүрэн дунд	667,244	501,266	39,333	627,911	-	644,317	22,927	75,050	25,972
-Дунд	205,308	159,898	14,960	190,348	-	203,600	1,708	17,841	9,770
-Бага	65,300	54,490	9,714	55,586	-	64,481	819	2,687	2,422

(Финтек ББСБ-ууд финтек уламжлалт зээл хослуулан олгодог болно)

Нийт харилцагчдын 92.4% буюу 3,454,675 нь, зээлдэгчдийн 94.0% буюу 2,427,549 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж (финтек), онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 7.6% буюу 284,638 нь, зээлдэгчдийн 6.0% буюу 153,785 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 38,100 буюу нийт харилцагчдын 1.0 хувийг бүрдүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Хүснэгт 5 Статистик мэдээлэл (5 жилээр)

Үзүүлэлтүүд	2021-I	2022-I	2023-I	2024-I	2025-I	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	17,339	21,788	28,353	33,850	35,807	1,957	5.8%
Ажилчдын тоо	3,517	4,322	4,735	5,385	6,197	812	15.1%
Харилцагчдын тоо	3,481,431	4,645,134	3,862,489	4,458,031	3,739,313	(718,718)	(16.1%)
Зээлдэгчдийн тоо	610,068	1,453,685	1,297,025	1,800,942	2,581,334	780,392	43.3%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	2.9%	3.1%	3.1%	3.6%	3.5%	(0.1%)	

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар буюу 1,957-өөр өсөж 35,807-г хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 96.8 хувь буюу 34,668 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,139 буюу 3.2% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 3,042 буюу 8.5% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 218 буюу 0.6% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна. ББСБ-ын салбарын нийт ажилтнуудын тоо өмнөх оны мөн үеэс 15.1 хувиар буюу 812 ажилтнаар нэмэгдэж 6,197-д хүрсэн байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	35,807	34,884	1,960	33,847	83	35,589	218	34,668	3,042
Нийт ажилтнуудын тоо	6,197	3,874	2,772	3,425	146	5,897	300	551	500
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	3,732	2,306	1,679	2,053	78	3,532	200	359	318
Эрэгтэй ажилтны тоо	2,465	1,568	1,093	1,372	68	2,365	100	192	182

Хөдөө орон нутгийн 96 ББСБ 7 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	575	90	503	72	61	479	96	5	570	28
1 Зээл	511	90	439	72	0	419	92	5	506	27
2 Факторингийн үйлчилгээ	55	31	32	23	0	51	4	3	52	1
3 Төлбөрийн баталгаа гаргах	28	15	21	7	0	27	1	2	26	3
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	5	0	6	0	6	0	1	5	0
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	54	26	30	24	0	52	2	3	51	2
6 Гадаад валютын арилжаа	178	37	148	30	61	162	16	4	174	8
7 Итгэлцлийн үйлчилгээ	90	90	50	40	0	86	4	5	85	5
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	50	30	33	17	0	47	3	3	47	4
9 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	0	0	1	0	0	1	1

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 83.3% буюу 479 ББСБ, салбаруудын 61.0% буюу 329 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 16.7% буюу 96 ББСБ, салбаруудын 38.8% буюу 209 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2025 оны I улирлын байдлаар 118 ББСБ-ын 539 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 55.8 хувийг 14 ББСБ-ын 301 салбар бүрдүүлж байна. Монголын ББСБ-уудаас анх удаа гадаад улсад албан ёсны салбараа нээлээ. Зээл, гадаад валют арилжаа болон цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй “Эдванс кредит ББСБ” ХХК нь 2024 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 342 дугаар тушаалаар Австрали улсын Брисбэн хотод салбартай болсон байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	479	329	808	100.0%
1. Сүхбаатар	162	44	206	25.5%
2. Чингэлтэй	130	33	163	20.2%
3. Баянзүрх	55	84	139	17.2%
4. Баянгол	66	42	108	13.4%
5. Хан-Уул	56	46	102	12.6%
6. Сонгинохайрхан	9	68	77	9.5%
7. Багануур	1	7	8	1.0%
8. Налайх	-	5	5	0.6%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Төв, аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	96	209	305	100%
Архангай аймаг	2	7	9	3.0%
Баян-Өлгий аймаг	3	5	8	2.6%
Баянхонгор аймаг	4	11	15	4.9%
Булган аймаг	2	2	4	1.3%
Говь-Алтай аймаг	1	2	3	1.0%
Говьсүмбэр аймаг	3	4	7	2.3%
Дархан-Уул аймаг	9	16	25	8.2%
Дорноговь аймаг	2	10	12	3.9%
Дорнод аймаг	5	20	25	8.2%
Дундговь аймаг	-	8	8	2.6%
Завхан аймаг	2	6	8	2.6%
Орхон аймаг	11	19	30	9.8%
Өвөрхангай аймаг	11	14	25	8.2%
Өмнөговь аймаг	2	19	21	6.9%
Сүхбаатар аймаг	5	7	12	3.9%
Сэлэнгэ аймаг	8	12	20	6.6%
Төв аймаг	18	9	27	8.9%
Увс аймаг	2	9	11	3.6%
Ховд аймаг	1	7	8	2.6%
Хөвсгөл аймаг	2	11	13	4.3%
Хэнтий аймаг	3	11	14	4.6%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2025 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 7.6 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49.5 хувиар буюу 2.5 их наяд төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 88.8 хувийг цэвэр зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх онтой харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр)

Активын үзүүлэлтүүд	2024-I		2025-I		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,819,018.8	95.2%	7,223,524.2	95.4%	2,404,505.4	49.9%
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	588,166.5	11.6%	662,130.5	8.7%	73,964.0	12.6%
Хөрөнгө оруулалт	57,563.6	1.1%	89,510.1	1.2%	31,946.5	55.5%
Зээл (цэврээр)	4,037,422.8	79.8%	6,263,240.7	82.8%	2,225,817.9	55.1%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	20,874.4	0.4%	51,927.5	0.7%	31,053.1	148.8%
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	1,651.7	0.0%	4,706.6	0.1%	3,054.8	184.9%
Бусад санхүүгийн хөрөнгө	113,339.8	2.2%	152,008.9	2.0%	38,669.0	34.1%
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	243,113.6	4.8%	344,862.2	4.6%	101,748.5	41.9%
Санхүүгийн бус бусад хөрөнгө	92,208.3	1.8%	129,371.0	1.7%	37,162.7	40.3%
Үндсэн хөрөнгө (цэврээр)	113,407.7	2.2%	150,087.4	2.0%	36,679.7	32.3%
Биет бус хөрөнгө (цэврээр)	37,497.6	0.7%	65,403.7	0.9%	27,906.1	74.4%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,062,132.4	100%	7,568,386.4	100%	2,506,254.0	49.5%


2025 оны I улирлын байдлаар ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 10.8 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 16.1 хувьтай тэнцэж байна.

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл)



Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2020 оны I улиралд 1,776.8 тэрбум төгрөг байсан бол 2025 оны I улирлын байдлаар 4.3 дахин өсөж 7,568.4 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь нийт зээлийн үлдэгдэл 5 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Салбарын нийт хөрөнгийн 98.1% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 407 ББСБ, 0.7% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 24 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 1.2 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 144 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал (тэрбум төгрөгөөр)

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	6,668.0	176	88.1%	30.6%	25.6	3	18.8	3	0.0	0
2.5-5.0 тэрбум	756.9	231	10.0%	40.2%	3.5	1	8.2	2	5.6	2
1.9-2.5 тэрбум	55.3	24	0.7%	4.2%	0	0	3.9	2	2.1	1
1.4-1.9 тэрбум	22.6	14	0.3%	2.4%	6.1	4	8.3	5	4.7	3
0.6-1.4 тэрбум	35.2	38	0.5%	6.6%	11.1	12	14.4	15	7.0	9
0.6 тэрбум хүртэлх	30.4	92	0.4%	16.0%	0	0	14.9	49	16.2	46
НИЙТ	7,568.4	575	100.0%	100.0%	46.3	20	68.6	76	35.5	61

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 4.3 их наяд төгрөг байгаа нь нийт активын 57.3 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 3.9 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 59.5 хувийг бүрдүүлж байна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 73.9 тэрбум төгрөгөөр буюу 12.6 хувиар өсөж 662.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 16.3 хувь нь бэлэн мөнгө хэлбэрээр, 64.8 хувь нь 3 хүртэлх сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад, 17.4 хувь нь 3-аас дээш сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад, 1.4 хувь нь мөнгөн хөрөнгөд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	662.1	345.8	354.8	307.3	32.7	643.1	19.1	117.9	120.0
Бэлэн мөнгө	108.1	5.1	103.0	5.2	24.9	100.8	7.3	0.3	1.7
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	429.3	254.3	208.2	221.0	7.2	419.5	9.7	92.4	89.8
Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	9.6	7.6	6.2	3.4	0.5	9.6	0.0	0.3	0.3
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (3-аас дээш сарын хугацаатай)	115.2	78.9	37.4	77.7	-	113.2	2.0	24.9	28.2

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 29.0%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 1.7%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 76.1% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 55.5 хувиар буюу 31.9 тэрбум төгрөгөөр өсөж, 2025 оны I улирлын байдлаар 38 ББСБ 89.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Хөрөнгө оруулалтын 0.2 хувь буюу 0.1 тэрбум төгрөг нь хадгаламжийн сертификат, 99.8 хувь буюу 89.4 тэрбум төгрөг нь үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл	Уламж- лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	89,510.1	83,267.9	22,740.8	66,769.3	1.0	87,979.2	1,530.9	44,334.7	36,584.6
Хадгаламжийн сертификат	138.3	115.8	22.5	115.8	0.0	138.3	0.0	0.0	0.0
Үнэт цаас	89,371.8	83,152.1	22,718.3	66,653.5	1.0	87,840.9	1,530.9	44,334.7	36,584.6
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	59,291.6	53,877.9	19,090.9	40,200.6	1.0	57,760.7	1,530.9	18,908.1	18,313.5
Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаас	9,411.9	9,010.9	1,626.0	7,785.9	0.0	9,411.9	0.0	7,074.6	0.0
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	19,046.3	19,046.3	1,482.0	17,564.3	0.0	19,046.3	0.0	17,564.3	17,564.3
Барьяанд байгаа үнэт цаас	398.4	0.0	398.4	0.0	0.0	398.4	0.0	0.0	0.0
Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,223.6	1,217.0	120.9	1,102.7	0.0	1,223.6	0.0	787.7	706.7
(Үнэт цаасны эрсдэлийн сан)	-	-	-	-	-	-	-	-	-

2025 оны I улирлын байдлаар богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөлтэй 50 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 38 ББСБ санхүүгийн тайлангаар хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 29 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Бусдаас эх үүсвэр татаж, түүгээрээ зөвшөөрөлгүйгээр богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагааг эрхэлсэн 4 ББСБ байгаа тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 54.7 хувь буюу 2.3 их наяд төгрөгөөр өсөж 2025 оны I улирлын байдлаар 6.6 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 309.7 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 6.3 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 14 Зээлийн бүтэц (тэрбум төгрөгөөр)


	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Зээл (цэврээр)	6,263.2	4,781.2	2,254.6	4,008.7	2.3	6,180.0	83.3	1,043.8	756.6
Зээл	6,572.9	4,996.5	2,374.8	4,198.1	2.3	6,481.7	91.2	1,110.0	805.2
Хэвийн	5,609.8	4,328.7	1,988.4	3,621.4	1.8	5,536.2	73.6	935.0	676.6
Анхаарал хандуулах	290.8	226.4	98.0	192.7	0.0	285.8	5.0	56.8	39.5
Чанаргүй зээл	424.8	286.2	175.1	249.7	0.1	415.0	9.8	81.1	61.6
-Хэвийн бус зээл	144.8	103.8	50.7	94.1	0.1	143.0	1.8	36.1	24.9
-Эргэлзээтэй зээл	107.1	71.5	42.0	65.1	0.0	105.4	1.7	23.1	14.9
-Муу зээл	172.9	110.9	82.4	90.5	0.1	166.6	6.2	21.9	21.8
(ЗЭС)	309.7	215.3	120.3	189.4	0.1	301.7	7.9	66.2	48.6
Хойшлогдсон төлбөр	3.7	3.5	1.1	2.5	0.0	3.7	0.0	2.4	2.4
Зээлд хур/тооцсон хүүгийн авлага	251.2	158.7	114.5	136.7	0.4	248.3	2.9	39.5	29.9
ЗЗ-ийн хүүнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

(Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно)

Шинэчлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн журамд зааснаар “Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна” гэж тодорхойлсон.

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг 1 ББСБ 2.3 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан ба нэр бүхий 1 ББСБ-ын зээлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг 2024.03.20-ны өдрийн 119 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон байна. Тайлант хугацаанд ББСБ-ууд 3.6 их наяд төгрөгийн зээлийг 3.5 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 3.0 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2025 оны I улирлын байдлаар 2.6 сая зээлдэгчийн 6.3 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Зураг 4 Зээлийн багцын чанар (тэрбум төгрөгөөр)



(Нийт зээлийн үлдэгдлийг зээлийн багцын нийлбэрээр тооцсон)

Зээлийн багцын 88.7 хувийг буюу 5.6 их наяд төгрөгийг хэвийн зээл, 4.6 хувийг буюу 290.8 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 6.7 хувийг буюу 424.8 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар (хувиар)



Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.7 пунктээр, чанаргүй зээлийн хэмжээ 0.2 пунктээр тус тус буурсан бол анхаарал хандуулах зээл 0.9 пунктээр өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 715.6 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 43.3 хувьд буюу 309.7 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2025 оны I улирлын байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 11.3% байна.

Олгосон зээлийн 94.1 хувь буюу 3.4 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 5.9 хувь буюу 214.4 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 94.7 хувь буюу 2.9 их наяд төгрөг нь иргэдээс, 5.3 хувь нь буюу 161.4 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

2025 оны I улирлын байдлаар 6.3 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа ба үүний 90.5 хувь буюу 5.7 их наяд төгрөгийг иргэдийн, 9.5 хувь буюу 603.1 тэрбум төгрөгийг хуулийн этгээдийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.


Хүснэгт 15 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар (сая төгрөгөөр)

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	21,306.1	0.6%	13,807.8	0.5%	68,841.8	1.1%
2.	Уул уурхай, олборлолт	25,334.1	0.7%	17,831.4	0.6%	85,699.3	1.4%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	19,888.9	0.6%	13,822.9	0.5%	58,824.6	0.9%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	2,825.0	0.1%	2,562.4	0.1%	10,079.8	0.2%
5.	Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	4,912.3	0.1%	773.6	0.0%	7,456.7	0.1%
6.	Барилга	71,222.2	2.0%	69,204.5	2.3%	308,305.6	4.9%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	241,841.9	6.7%	191,661.6	6.3%	697,077.1	11.0%
8.	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	69,343.4	1.9%	44,813.6	1.5%	169,255.1	2.7%
9.	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	18,381.8	0.5%	27,847.7	0.9%	89,812.5	1.4%
10.	Мэдээлэл, холбоо	29,709.3	0.8%	20,173.6	0.7%	113,866.5	1.8%
11.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	51,053.9	1.4%	45,412.2	1.5%	49,015.7	0.8%
12.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	34,037.2	0.9%	22,753.4	0.8%	101,115.8	1.6%
13.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3,265.5	0.1%	3,746.9	0.1%	14,893.2	0.2%
14.	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	4,149.5	0.1%	3,403.4	0.1%	18,068.3	0.3%
15.	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	4,694.5	0.1%	4,622.1	0.2%	16,212.3	0.3%
16.	Боловсрол	15,965.8	0.4%	12,616.7	0.4%	28,837.1	0.5%
17.	Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	9,615.4	0.3%	6,441.1	0.2%	30,597.3	0.5%
18.	Урлаг, үзвэр, тоглоом наадам	19,259.2	0.5%	15,407.1	0.5%	32,361.8	0.5%
19.	Бусад	2,962,851.2	82.1%	2,514,887.2	83.0%	4,425,018.8	70.0%
<i>Иргэнд олгосон зээл</i>		3,395,288.6	94.1%	2,870,361.7	94.7%	5,722,198.3	90.5%
<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>		214,368.5	5.9%	161,427.5	5.3%	603,140.9	9.5%
НИЙТ		3,609,657.1	100%	3,031,789.2	100%	6,325,339.1	100.0%

Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “[Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал](#)”-аар нийт олгосон зээлийн 82.1% буюу 3.0 их наяд төгрөг нь бусад ангилалд (ихэвчлэн хэрэглээний зээл), 6.7% буюу 241.8 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 83.0% буюу 2.5 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 6.3% буюу 191.7 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Тайлант улиралд олгосон зээлийг хугацааны ангиллаар харвал 1 сар хүртэлх хугацаатай олгосон зээл нийт зээлийн 25.4 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 21.8 хувийг, 1-2.5 жил, 2.6-5 жил хүртэлх хугацаатай олгосон зээл тус тус нийт зээлийн 15.9 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 6 Олгосон зээл (хугацааны ангиллаар)



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 6.3 их наядын зээлийн 60.3 хувийг иргэний хэрэглээний зээлийн үлдэгдэл, үүнээс 26.1 хувийг автомашинд зориулсан зээлийн үлдэгдэл, 8.2 хувийг хуулийн этгээдийн бизнесийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Хүснэгт 16 Зээлийн ангилал (тэрбум төгрөгөөр)

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	3,395.3	94.1%	2,870.4	94.7%	5,722.2	90.5%
Хэрэглээнд зориулсан зээл	2,605.8	72.2%	2,248.5	74.2%	3,815.5	60.3%
Үүнээс: Автомашинд зориулсан зээл	431.0	11.9%	321.1	10.6%	1,650.1	26.1%
Бизнес зориулсан зээл	435.0	12.1%	329.4	10.9%	1,044.0	16.5%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	36.1	1.0%	36.3	1.2%	180.5	2.9%
Бусад зээл	318.4	8.8%	256.2	8.4%	682.1	10.8%
Хуулийн этгээдэд олгосон зээл	214.4	5.9%	161.4	5.3%	603.1	9.5%
Бизнесийн зээл	161.6	4.5%	113.4	3.7%	520.1	8.2%
Автомашин зээл	1.6	0.0%	2.6	0.1%	11.7	0.2%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	2.5	0.1%	2.2	0.1%	9.5	0.1%
Бусад зээл	48.7	1.3%	43.1	1.4%	61.9	1.0%
НИЙТ	3,609.7	100%	3,031.8	100%	6,325.3	100%

Цахим зээл

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй 72 ББСБ 67 финтек зээлийн аппликэйшнээр дамжуулж цахим зээлийн үйлчилгээ үзүүлж байна.

Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)

	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	4,489,678,260.4	71.0%	292,244	11.3%	15,362.8
Цахим зээл	1,835,660,875.7	29.0%	2,289,090	88.7%	801.9
Нийт	6,325,339,136.1	100.0%	2,581,334	100.0%	2,450.4

2025 оны I улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 2.3 сая зээлдэгчийн 1.8 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 88.7 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 29.0 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 801.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 19.2 дахин бага байна. Цахим зээлийн мэдээлэл ирүүлээгүй 22 ББСБ-уудад холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байна.

Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд (мянган төгрөгөөр)

№	Финтек	App нэр	Бүртгүүлсэн огноо
1	Анлок капитал	Unlock Finance	2024.04.23-№7/1442
2	Кэйш флов финанс	Tugrug App	2024.02.21-№7/632
3	Мобифинанс	Monpay	2023.06.20-№7/2540
4	Покет	Pocket.mn	2023.05.08-№7/1871
5	Тус финтек	Tus fintech	2023.05.19-№7/2125
6	Лэндмн	LendMN	2023.06.20-№7/2550
7	Таван богд финанс	PayOn.mn	2023.07.04-№7/2826
8	Инвескор	InvesCore Pocket.mn	2023.08.25-№7/3350 2023.05.25
9	Ашид капитал	Simple.mn	2023.11.10-№7/4317
10	Нөмөр кредит	Numur	2023.03.03-№7/890
11	ТОКИ	Toki	2023.06.20-№7/2549
12	Ардкредит	Ard	2023.12.22-№7/4873
13	Омни капитал	Moni	2023.07.05-№7/2869
14	Сэндли	Sendly	2023.07.04-№7/2821
15	Нэт капитал финанс корпораци	NetPay	2023.07.04-№7/2825
16	Хатан суудал инвест	Zeely	2023.03.03-№7/894
17	Соломон инвестментс	M credit	2023.11.10-№7/4319
18	Ньюстар финанс	Nsf.mn Lite+	2023.06.20-№7/2552
19	Дэвжих нэхий	Money-T	2023.12.22-№7/4870
20	Очир ундраа ОМЗ	Opay MN	2023.08.25-№7/3351
21	Гэрэлфинанс	Gerel	2023.05.08-№7/1872
22	Бизнес-Инвест девелопмент	BiD	2023.08.25-№7/3353
23	Си И Си инвестмент	Pocket.mn	2024.04.24
24	Номин юнити	OmniWay Nomin Unity	2024.02.21-№7/634 2024.04.23-№7/1443
25	Мөнгөнзоос кредит	Pocket.mn	2023.05.24
26	Цогзолфинанс	Pocket.mn	2023.05.23

27 Сэнд эм эн	SendMN Pocket.mn"	2024.02.21-№7/636 2023.12.20
28 Энт кредит инвестмент	EntCreditMN	2023.03.03-№7/891
29 Жи Эс Би капитал	Prime	2024.02.21-№7/631
30 Фирруут-Инвестмент	Pocket.mn	2023.05.24
31 Грийн-Инвестмент	Gate.mn	2023.07.04-№7/2827
32 Хас хаан	ХАСХААН	2023.06.20-№7/2551
33 Төвхөн ингүүмэл	Oneclick.mn	2024.07.09-№7/2534
34 Финко капитал	Beep	2024.09.23-№7/3172
35 Их Монгол кредит	Ikh Mongol Credit	2024.02.21-№7/633
36 Микрокредит	Easy	2023.12.22-№7/4871
37 Алтан зоос капитал	ZOOS	2024.05.30-№7/2046
38 Жи би си си	E-zeel	2023.03.03-№7/889
39 Девелопинг энтрепрениориал монголиа	DEM.mn	2024.05.30-№7/2045
40 Гурван зуун жар файнанс	Minu pay	2023.07.04-№7/2822
41 Их ирээдүй капитал	Easy loan	2024.05.30-№7/2043
42 Инвеско фонд	IF.mn	2023.08.25-№7/3349
43 Өсөх ундарга финанс	Ufinance	2024.09.23-№7/3171
44 Нанокапитал	Nano Capital	2023.07.04-№7/2824
45 Вишинфанд	Вишинфанд	2024.12.04-№7/3982
46 Онч-Энх	Ugloo	2023.03.30-№7/1297
47 Мэйн стрит финанс	Pays	2025.02.11-№3/425
48 Хангууд финанс	Khanguud	2023.12.22-№7/4872
49 Магна профит энд инвестмэнт	Magna.mn	2024.02.21-№7/635
50 Улаанбаатар кредит	Uray	2024.12.16-№7/4110
51 Соно финтек	Sono Mongolia	2023.03.03-№7/895
52 Зээл Эм Эн платформ	Zeel.mn	2023.07.04-№7/2828
53 Есөн финанс	MetaLend	2023.08.25-№7/3352
54 Изи пэй норбула	Easypay.mn	2023.12.22-№7/4867
55 Балансэд кредит	Balance	2024.12.04-№7/3981
56 БСБ финанс	BSB Finance	2025.02.11-№3/427
57 Говь финанс	CashOne	2023.08.25-№7/3354
58 Гоулдман инвестмент	Goldpay	2023.08.25-№7/3355
59 Дарь финанс	Pocket.mn	2024.03.01
60 Есөн эрдэнэ финанс	Leasing.mn	2023.03.30-№7/1298
61 Монголиа импакт финанс	Qmoni	2023.08.25-№7/3356
62 Монголиан юнайтед кредит	UniPay.mn	2024.12.04-№7/3979
63 Монголын санхүүгийн групп	Мост мони	2024.12.25
64 Монкор финанс	T-Friend	2024.07.09-№7/2535
65 Навитас фонд	Pocket.mn	2025.02.03
66 Прогресс финтек	Zuut	2024.05.30-№7/2044
67 Тапапэй	Tapatrip	2024.09.24-№7/3174
68 Үнэт кредит	M credit	2024.12.05
69 Франкфурт капитал	Nar app	2023.07.04-№7/2823
70 Хексинг финанс	Sign Finance	2024.12.04-№7/3980
71 Централ капитал	Kmobimn	2024.04.23-№7/1441
72 Эм Эл Жи финанс Юү Би	ANDA	2024.07.09-№7/2536

*/"Инвекор ББСБ" ХК-ийн Pocket аппликэйшнд бүртгэлтэй 8 ББСБ байна.
Зөвхөн аппликэйшнээр зээл олгож байгаа 5 ББСБ-ыг шараар тэмдэглэв/*

2025 оны I улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд финтек зээлийн бүтээгдэхүүн бүртгүүлсэн 72 ББСБ байна.

Ногоон зээл

